Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн
60 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль |
| Дагаж мөрдөх огноо: | 2022 оны 01 дүгээр сарын 01 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Гаалийн ерөнхий газрын харьяа ...........................................гаалийн газар | Гаалийн газар, хороо |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
| Хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн албаны дарга | Дэс түшмэл ТТ-4 |
| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | Улаанбаатар хот болон орон нутаг дахь хаяг |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
2. Гаалийн нутаг дэвсгэрт эрсдэлийн удирдлагад суурилсан бичиг баримтын бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, улсын төсвийн гаалийн орлогыг бүрдүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
3. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, худалдааг хөнгөвчлөх чиг үүргийн хэрэгжилтийг хангах;
4. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн хяналтын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөмж үзүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх-Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн хяналттай холбоотой олон улсын гэрээ, конвенц болон хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих; | Өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдсан байдал | Г, Т |
| | 2. Гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хяналтад бүрэн хамруулж, хяналтын тоног төхөөрөмжийг гаалийн хяналтад үр дүнтэй ашиглах, хэвийн үйл ажиллагааг хангах; | Гаалийн хяналт сайжирсан байх | Г |
| | 3. Гаалийн хяналтын бүс, гаалийн баталгаат бүс, итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах; | Журмын шаардлага хангагдсан байна | Х |
| | 4. Гаалийн хяналтын технологи ажиллагааны зааврын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай тохиолдолд тухай бүр шинэчлэх ажлыг зохион байгуулах; | Гаалийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулсан байна | Х, Г |
| | 5. Хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд ажлын ачааллад үндэслэн гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг хуваарилах; | Нөөцийг үр дүнтэй ашигласан байх | Г |
| | 6. Газрын удирдлагад гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой гарсан өргөдөл (хүсэлт, гомдол, маргаан), цаг үеийн чанартай хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; | Хуулийн хүрээнд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байх | Т |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 7. Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, хяналтын тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хяналтад тогтмол ашиглах ажлыг зохион байгуулж, хяналт тавих. | Гаалийн хяналтад тогтмол ашигласан байдал | Х, Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Гаалийн мэдүүлэг, гаалийн мэдээллийн сангийн бүрдэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих; | Гаалийн мэдүүлэг, мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдал | Г, Х |
| | 2. Гаалийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн горим, барааны ангилал, гарал үүсэл, гаалийн тариф, гаалийн үнэ, үнэлгээ, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт тавих, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих; | Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой зөрчлийн бууралт, үр дүн | Г, Х |
| | 3. Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгж, албан тушаалтантай уялдаа холбоотой ажиллах; | Уялдаа холбоо сайжирсан байдал, үр дүн | Г |
| | 4. Улсын төсвийн гаалийн орлогыг бүрдүүлэх чиглэлээр хэрэгцээ шаардлагаа тодорхойлон, холбогдох санал боловсруулан удирдах төв байгууллагад хүргүүлэх, дүн шинжилгээ хийх; | Дүн шинжилгээ бодитой, үнэн зөв гарсан байдал | Г, Х |
| | 5. Түр горимын гаалийн бүрдүүлэлтийн хугацаанд хяналт тавьж, татварын өр авлага үүсгэхгүй байх, Засгийн газрын тогтоолын дагуу татвар хойшлогдсон болон хэсэгчлэн төлөх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах; | Журмын дагуу хэрэгжсэн байдал, үр дүн | Г, Х |
| | 6. Газрын хэмжээнд экспорт, импортын статистик мэдээ гаргах, дүн шинжилгээ хийх, улсын хилээр нэвтрүүлж буй бараанд магадлан шинжилгээ хийх, лабораторийн дүгнэлт гаргах ажилд хяналт тавих. | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байх | Х, Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Гаалийн хилээр хүний хөл хориот, малын гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдолд хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байх | Г, Т |

МОНГОЛ УЛС ... ЗОВШООРОВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2. Гаалийн хилээр хорио цээрийн хяналтад хамрагдах бараа, бүтээгдэхүүнд эрсдэлийн удирдлагад суурилсан хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байх | Г, Т |
| | 3. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, гаалийн харилцаанд оролцогч, хилийн хяналтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах; | Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан байдал, үр дүн | Г |
| | 4. Гаалийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаалийн удирдах төв байгууллага болон газрын удирдлагаас өгсөн удирдамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх; | Үүрэг даалгаврын биелэлт, гаалийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлсэн байдал, үр дүн | Г |
| | 5. Гаалийн удирдах төв байгууллагын чиг үүрэг, бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд хил залгаа орны болон гадаад орны гаалийн байгууллагатай хамтран ажиллах; | Хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан байдал | Г |
| | 6. Гаалийн хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгцээ шаардлагаа тодорхойлон, холбогдох санал боловсруулан газрын удирдлагад танилцуулах. | Санал өгсөн байдал | Т |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гаалийн хяналт, шалгалтыг оновчтой зохион байгуулах ажлыг төлөвлөх, биелэлтийг хангуулах, тайлагнах ажлыг хариуцан гүйцэтгэх; | Хэрэгжүүлсэн ажил, үр дүн | Г |
| | 2. Газрын хэмжээнд мөрдөгдөх гаалийн хяналтын технологи ажиллагааны зааврыг мөрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; | Зааврыг мөрдөж ажилласан байдал | Г |
| | 3. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн хяналттай холбоотой програм хангамжийн уялдаа холбоог хангах, гаалийн автоматжуулсан системийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Г |

МОНГОЛ УЛС ... ЗӨВШӨӨРСӨН ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 4. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна | Т |
| | 5. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичиг хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулах; | Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна | Х |
| | 6. Гаалийн удирдах төв байгууллага, орон нутгаас зохион байгуулах хурал, цуглаан, олон нийтийг хамруулсан бусад арга хэмжээнд газрын хамт олныг удирдан зохион байгуулан оролцох, хамт олны хурал зарлан, өөрийн шууд харьяанд ажиллах ажилтнуудад мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах. | Хамт олныг хамруулан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн | Г, Ш |

**III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА**

| | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | - Эрүүл ахуй, тархвар судлал (102101),<br>- нийгмийн эрүүл мэнд (098801),<br>- мал эмнэлэг (084),<br>- хөдөө аж ахуй (0811-0812, 0831),<br>- худалдаа (0416),<br>- бараа, түүхий эдийн судлал, технологи (072205),<br>- эрх зүй (042),<br>- менежмент ба удирдахуй (041303, 041305, 041306, 041307),<br>- эдийн засаг (0311),<br>- аюулгүй байдал хангах (103). | |
| Мэргэшил | Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - гаалийн харилцаанд оролцогчидтой үр дүнтэй харилцах;<br>- албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;<br>- албаны албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах;<br>- байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;<br>- нэн тэргүүний ажлыг тодорхойлоход чиглэл, зааварчилгаа өгөх; |

| | | |
|---|---|---|
| | | - бусад. |
| | Дүн шинжилгээ хийх | - мэдээллийн алдаатай болон дутуу, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн болон хорио цээрийн хяналт тавих ажлыг боловсронгуй болгох асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;<br>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж дүгнэх;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>- удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу албаны чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг оновчтой зохион байгуулах;<br>- бусад. |
| | Манлайлах | - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- хувийн зохион байгуулалт, ёс зүйгээр хамт олноо манлайлан, үлгэр дууриалал үзүүлэх;<br>- албаны үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, бүтээлч санаачилгатай ажиллах;<br>- албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;<br>- бусад. |
| | Бусад | - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- гадаад худалдаа, гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцан, өөрийгөө хөгжүүлэх;<br>- гаалийн байгууллагын бодлого, чиг хандлагыг амаар болон бичгээр илэрхийлэх, хэвлэл болон олон нийтийн мэдээллийг шүүн тунгаах чадвар;<br>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- монгол хэл бичгийн мэдлэгийн түвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;<br>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, |

| | | |
|---|---|---|
| | | бусдад таниулах.<br>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, гаалийн харилцаанд оролцогчидтой харилцах. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Газрын дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| | - Төрийн байгууллагын холбогдох ажилтан;<br>- Гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд;<br>- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хорооны дарга, , албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br><br>ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА<br><br>......................................Ч.ТАМИРАА<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2023 оны 4... сарын 11-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 23 03 0[illegible]<br><br>Дугаар: 060 |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: ..................................

Дугаар: ..............

(тамга/тэмдэг)

ДАРГА................................................Р.ОТГОНЖАРГАЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны 04. дугаар сарын 12 -ны өдөр

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ